

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ХУУЛЬ БУС ҮЙЛДЭЛ, ЭС ҮЙЛДЭХҮЙН ТАЛААР ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

УВС АЙМАГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТЫН ДҮН

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг Эрхзүйн зөв хөтөч ТББ-д “Цагдаагийн алба хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн талаар гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт” сэдвийн хүрээнд мониторинг хийх тэтгэлэг олгосон билээ. Мониторингид 2014-2017 онд Увс аймгийн ЗДТГ-ын 70452222 тоот утсанд болон иргэд, хуулийн этгээдээс цагдаагийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийг хамруулсан болно.

Мониторингийн гол үр дүн, зөвлөмжийг энэхүү цувралаар олон нийтэд хүргэж байгаа бөгөөд дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.


МОНИТОРИНГИЙН ДҮН

- Цагдаагийн алба хаагчтай холбоотой асуудлаар гаргасан иргэдийн өргөдөл, гомдлыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа сайн тал ажиглагдсан. Харин мониторингийн явцад авсан санал асуулгын дүнгээс харахад цагдаагийн алба хаагчид, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулж, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлэх шаардлагатай байгаа нь харгадлаа.

Зөрчлийн талаарх мэдээлэл

- Увс аймагт 2014-2017 онд цагдаагийн албан хаагчийн хууль бус үйлдэлд хамаарах нийт 83 зөрчлийн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг харахад 20.8 хувийг үндэслэлгүй гэж үзжээ. Дээрх хугацаанд гарсан зөрчил, холбогдсон алба хаагчдын статистик мэдээллийг он тус бүрээр График 1-д харуулав.

График 1. Зөрчлийн статистик мэдээлэл, 2014-2017 он



- Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзэхэд архидаан согтуурсан, бусдын эрхэнд халдсан, сахилгын зөрчил гаргасан, ажилдаа хайнга хандсан зөрчлүүд зонхилж байна (График 2).

График 2. Цагдаагийн алба хаагчийн гаргасан зөрчлийн төрөл /Увс аймагт/



- Зөрчил гаргасан албан хаагчийн цалинг 1-6 сарын хугацаанд 10-20 хувиар бууруулах, албанаас нь халах гэх зэрэг шийтгэл оногдуулсан ба зөрчил гаргасан алба хаагчдын дийлэнх нь дээд боловсролтой байна (График 3, 4).

График 3. Гаргасан зөрчилд оногдуулсан шийтгэл





График 4. Зөрчил гаргасан алба хаагчдын албан тушаалын байдал



- Зөрчил гаргасан алба хаагчдын 67,7 хувь нь сумдад ажилладаг алба хаагч байгаа нь анхаарал татаж байна.

Санал асуулгын дүн

- Мониторингийн явцад иргэд болон алба хаагчдыг хамруулан авсан судалгаагаар талууд аль алиндаа шүүмжлэлтэй хандаж байгаа нь ажиглагдсан. Үүнээс харахад цагдаагийн алба хаагчид, иргэдийн хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл сул байгаа бөгөөд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Судалгааны дүнг товчлон харуулбал:
 - Нийт 320 иргэнээс авсан санал асуулгын дүнгээр судалгаанд оролцсон иргэдийн 71.2 хувь цагдаагийн алба хаагчдыг иргэдийн үгийг сонсдоггүй, дээрэлхүү, ялгамжтай харьцдаг, хүнд сурталтай, эрх зүйн боловсрол муу гэж хариулжээ.
 - Харин нийт алба хаагчдын 30,7 хувийг оролцуулан үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээл, шийдэх арга замын талаар асуулга авахад нийт оролцогчдын 66.6 хувь нь иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх шаардлагатай гэжээ. Түүнчлэн 9.6 хувь нь зүй ёсны шаардлагыг иргэд хүлээж авдаггүй, 8.7 хувь нь техник хэрэгсэл хангалтгүй, 3 хувь нь алба хаагчдын харьцааны соёл дутмаг гэжээ. Мөн оролцогчдын 12.1 хувь Зөрчлийн хуульд торгуулийн хэмжээ өндөр байгаа нь цагдаа, иргэн хоорондын харилцаанд сөрөг байдал үүсгэж байна хэмээн үзсэн байна.

Алба хаагчийн холбогдож буй дээрх хэрэг зөрчилд аймгийн Цагдаагийн газар дүгнэлт хийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэстэй хамтран “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйг дээшлүүлэх нэг сарын аян” зохион байгуулж, алба хаагчдыг ёс зүйн сургалтад хамруулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдтэй зөв боловсон харьцах талаар уриалга гаргаж ажиллажээ.

ЗӨВЛӨМЖ

- Цагдаагийн алба хаагчдыг хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр системтэй ажил зохион байгуулах;
- Ялангуяа сумдад ажиллаж буй алба хаагчдыг хэрэг, зөрчилд холбогдохоос сэргийлсэн цогц арга хэмжээ авах;
- Цагдаагийн албаны үйл ажиллагаа, онцлогийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх замаар иргэдийн эрх зүйн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Иргэд, цагдаагийн алба хаагчдын оролцоотой нээлттэй хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах;
- Цагдаагийн байгууллагын тайланг улирал бүр иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг Эрхзүйн зөв хөтөч ТББ-аас Цагдаагийн алба хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн талаар гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хийсэн мониторингийн үр дүнг нийтлэв. Энэхүү мониторинг нь Эрхзүйн зөв хөтөч ТББ-аас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.